



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/44/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд хот

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас:70523020

Цахим хаяг: DORNOGOVI@AUDIT.COM

Ц.Лүндэгмаа

Цахим хаяг: Lundegmaa.ts@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын тайлан	5
1.1	Оршил	5
1.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
1.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
1.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
1.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
1.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
1.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
1.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
1.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
1.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	9
1.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
	Өөрийн үйл ажиллагааны орлогыг 337.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ.	10
1.11	Шилэн дансны мэдээлэл	10
1.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
1.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайванданд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 2019.02.25 № 1-6/170 танай _____ -ны № _____ -т	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА Д.ГАНТӨМӨР ТАНАА
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Иххэт сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Иххэт сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

Үүрэг, хариуцлага

Иххэт сумын Засаг даргын Тамгын газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЗДТГ-ын дарга Д.Гантөмөрт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019-02-18-наас 2019-02-19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019-02-19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Иххэт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019-01-25-ны өдрийн 06/68 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Иххэт сумын ЗДТГ нь Төр эдийн засаг, нийгмийн бодлогын үйл ажиллагаа гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Иххэт сумын ЗДТГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгөөс материаллаг байдлын түвшинг тогтооход өндөр гарч байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг түвшинг тогтоов.

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ 2018 оны нийт зардал 4,817.10 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 4,817.10 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцов.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	100.00	
3	Албан шаардлага өгсөн	1	0.00	

4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00
	Дүн	1	100.00

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1.8.2 Цалин хөлсний зардал

ЗДТГ-ын үйлчлэгч Д.Нарантуяад 200.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгосон ба 100.0 мянган төгрөгийн цалинг дутуу суутгасан байна.

Энэ нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно”, мөн Монгол улсын Сангийн сайдын 388 тоот тушаалаар баталсан НББ-ийн дансны зааврын 4.52-д “Тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор өр төлбөр нь барагдах ёстой” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дутуу суутгасан урьдчилгаа цалин 100.0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

1.8.3 Бараа материалын данс

Эд хариуцагч түлш шатах тослох материалын тайланд 815.0 мянган төгрөгийн шатахуун, аж ахуй материалын тайланд 73.7 мянган төгрөгийн материалыг орлого авалгүйгээр тайлан гаргасан байна.

Энэ нь Эд хариуцагчийн эрх, үүргийн дүрмийн 17-д “Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Аж ахуйн материал, түлш шатах тослох материалын тайланд залруулга хийв.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 277,576.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 274,813.2 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласантай холбоотой цалин хөлс, НДШ-ийн зардал нийт дүнгээр 1,872.2 сая төгрөгөөр хэмнэгдэн үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Өөрийн үйл ажиллагааны орлогыг 337.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Иххэт сумын ЗДТГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангаар аудитын түүвэрт хамрагдсан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,281,790.45	36,863,210.85
33	АВЛАГА	21,709,075.00	14,227,475.00
335	Бусад авлага	21,709,075.00	14,227,475.00
3351	Байгууллагаас авах авлага	21,709,075.00	14,227,475.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,572,715.45	22,635,735.85
351	Түүхий эд материал	8,984,452.62	7,110,452.62
35110	Тусгай зориулалттай материал	8,984,452.62	7,110,452.62
354	Хангамжийн материал	13,224,582.83	14,161,603.23
35410	Бичиг хэргийн материал	726,060.00	1,190,300.00
35420	Аж ахуйн материал	8,598,522.83	9,071,303.23
35470	Бусад хангамжийн материал	3,900,000.00	3,900,000.00
35500	Биологийн хөрөнгө	00.00	00.00
35600	Мал амьтад	1,363,680.00	1,363,680.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	744,910,363.78	1,240,113,755.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	744,910,363.78	1,240,113,755.93
392	Биет хөрөнгө	744,864,530.54	1,167,289,422.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	374,348,579.00	641,441,959.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-222,638,900.14	-5,131,968.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	252,418,000.00	279,277,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-158,900,191.97	-187,511,461.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	89,898,120.58	86,659,722.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	-62,152,448.29	-67,642,533.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,261,743.76	74,620,525.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,278,901.71	-44,683,480.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	679,769,937.80	698,669,937.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-253,861,408.49	-308,410,778.31
393	Биет бус хөрөнгө	45,833.24	72,824,333.20
39301	Програм хангамж	3,075,000.00	3,075,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,029,166.76	-3,056,666.80
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	72,806,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	790,192,154.23	1,276,976,966.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,122,382.00	23,431,674.39
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,122,382.00	23,431,674.39
413	Өглөг	14,122,382.00	23,431,674.39
4136	Бусад өглөг	14,122,382.00	23,431,674.39
41361	Байгууллагад төлөх өглөг	9,041,382.00	14,215,674.39
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,081,000.00	9,216,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	776,069,772.23	1,253,545,292.39
51	Засгийн газрын хувь оролцоо	776,069,772.23	1,253,545,292.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	690,025,468.56	762,831,468.56
51101	Өмч: - төрийн	690,025,468.56	762,831,468.56
512	Хуримтлагдсан үр дүн	15,226,154.43	-52,215,536.65
51210	Өмнөх үеийн үр дүн	15,226,154.43	15,226,154.43
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-67,441,691.08
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	70,818,149.24	542,929,360.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	790,192,154.23	1,276,976,966.78

3.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	133,841,894.80	414,268,270.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,523,032.80	93,795,592.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,523,032.80	93,795,592.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,183,532.80	92,305,550.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,183,532.80	92,305,550.00
120005	Түрээсийн орлого	339,500.00	1,490,042.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	132,318,862.00	320,472,678.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	111,688,600.00	276,576,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,688,600.00	276,576,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,630,262.00	43,896,678.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,630,262.00	43,896,678.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	177,824,793.70	463,030,757.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	177,824,793.70	463,030,757.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177,824,793.70	457,639,120.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	80,568,212.00	165,430,626.00
210101	Үндсэн цалин	79,818,212.00	162,430,626.00
210104	Урамшуулал	750,000.00	3,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,900,338.00	19,498,637.00
210201	Тэтгэврийн даатгал	5,736,718.00	13,301,312.00
210202	Тэтгэмжийн даатгал	656,669.00	1,515,558.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	804,518.00	1,313,026.00
210204	Ажилгүйдлийн даатгал	157,732.00	311,921.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,544,701.00	3,056,820.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,525,796.00	48,135,211.00
210301	Гэрэл, цахилгаан	989,416.00	1,920,234.00
210302	Түлш, халаалт	24,173,556.00	45,223,155.00
210303	Цэвэр, бохир ус	362,824.00	991,822.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,279,481.60	39,882,815.99
210401	Бичиг хэрэг	1,071,455.00	2,409,861.00
210402	Тээвэр, шатахуун	6,782,167.60	24,778,402.39
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	107,359.00	4,107,243.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	3,023,490.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	318,500.00	1,723,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	3,839,919.60
2105	Нормативт зардал	00.00	173,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	173,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,000.00	351,000.00
210604	Урсгал засвар	18,000.00	351,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,523,300.00	8,222,800.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,523,300.00	8,222,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,575,342.00	8,096,065.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	756,000.00	7,351,740.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	193,350.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	418,992.00	459,325.00

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	57,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00
210807	Газрын төлбөр	00.00	175,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,434,324.10	167,848,965.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,065,500.00	43,058,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,368,824.10	124,790,165.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	5,391,637.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	2,291,840.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	91,840.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,099,797.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,099,797.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-43,982,898.90	-48,762,487.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	18,679,204.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	871,490.88
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	17,807,713.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-18,679,204.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-43,982,898.90	-67,441,691.08

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	132,658,362.00	341,261,795.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	339,500.00	1,337,042.00
120	Нийтлэг татварын бус орлого	339,500.00	1,337,042.00
120005	Түрээсийн орлого	339,500.00	1,337,042.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	132,318,862.00	339,924,753.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	111,688,600.00	276,576,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,688,600.00	276,576,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,630,262.00	63,348,753.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,630,262.00	63,348,753.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	108,561,189.00	340,871,795.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	108,561,189.00	340,871,795.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,561,189.00	321,315,683.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	84,047,323.00	165,320,229.00
210101	Үндсэн цалин	83,297,323.00	162,320,229.00
210104	Урамшуулал	750,000.00	3,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,220,867.00	19,456,034.00
210201	Тэтгэврийн даатгал	5,801,386.00	12,430,672.00
210202	Тэтгэмжийн даатгал	683,895.00	1,623,463.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	854,860.00	1,327,835.00
210204	Ажилгүйдлийн даатгал	170,975.00	312,882.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,709,751.00	3,761,182.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,751,640.00	45,941,211.00
210301	Гэрэл, цахилгаан	989,416.00	1,864,260.00
210302	Түлш, халаалт	4,412,600.00	43,029,155.00
210303	Цэвэр, бохир ус	349,624.00	1,047,796.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,377,217.00	30,158,844.00
210401	Бичиг хэрэг	678,000.00	2,435,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,325,458.00	18,929,338.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	107,359.00	4,140,206.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,266,400.00	3,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	853,900.00
2105	Нормативт зардал	00.00	173,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	173,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	3,816,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,940,000.00
210604	Урсгал засвар	00.00	1,876,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,523,300.00	4,082,800.00
210702	Дотоод албан томилолт	1,523,300.00	4,082,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,575,342.00	9,308,765.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	756,000.00	8,485,540.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	193,350.00	166,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	418,992.00	292,925.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	57,000.00	188,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00
210807	Газрын төлбөр	00.00	175,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,065,500.00	43,058,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,065,500.00	43,058,800.00

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	19,556,112.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	2,291,840.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,291,840.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	17,264,272.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	17,264,272.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,097,173.00	390,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	390,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	390,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	390,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	390,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-390,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	24,097,173.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,097,173.00	00.00

3.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	690,025,468.56	70,818,149.24	15,226,154.43	776,069,772.23
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	690,025,468.56	70,818,149.24	15,226,154.43	776,069,772.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	690,025,468.56	70,818,149.24	15,226,154.43	776,069,772.23
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	472,111,211.24	00.00	472,111,211.24
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	72,806,000.00	00.00	-67,441,691.08	5,364,308.92
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	762,831,468.56	542,929,360.48	-52,215,536.65	1,253,545,292.39

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	277,576,000.00	274,813,245.00	2,762,755.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	277,576,000.00	274,813,245.00	2,762,755.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	277,576,000.00	274,813,245.00	2,762,755.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,653,900.00	162,320,229.00	333,671.00
210101	Үндсэн цалин	162,653,900.00	162,320,229.00	333,671.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,994,400.00	19,456,034.00	1,538,366.00
210201	Тэтгэврийн даатгал	13,097,000.00	12,430,672.00	666,328.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,585,300.00	1,623,463.00	-38,163.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,361,500.00	1,327,835.00	33,665.00
210204	Ажилгүйдлийн даатгал	327,400.00	312,882.00	14,518.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,623,200.00	3,761,182.00	862,018.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,001,700.00	45,941,211.00	60,489.00
210301	Гэрэл, цахилгаан	1,907,300.00	1,864,260.00	43,040.00
210302	Түлш, халаалт	43,052,600.00	43,029,155.00	23,445.00
210303	Цэвэр, бохир ус	1,041,800.00	1,047,796.00	-5,996.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,684,300.00	29,942,306.00	741,994.00
210401	Бичиг хэрэг	3,187,500.00	2,825,400.00	362,100.00
210402	Тээвэр, шатахуун	18,332,800.00	18,332,800.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,264,000.00	4,130,206.00	133,794.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,800,000.00	3,800,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,100,000.00	853,900.00	246,100.00
2105	Нормативт зардал	200,000.00	173,000.00	27,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	173,000.00	27,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,816,000.00	3,816,000.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,940,000.00	1,940,000.00	0.00
210604	Урсгал засвар	1,876,000.00	1,876,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	4,108,000.00	4,082,800.00	25,200.00
210702	Дотоод албан томилолт	4,108,000.00	4,082,800.00	25,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,117,700.00	9,081,665.00	36,035.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,269,000.00	8,258,440.00	10,560.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	166,400.00	166,400.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	303,800.00	292,925.00	10,875.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	203,500.00	188,900.00	14,600.00
210807	Газрын төлбөр	175,000.00	175,000.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	277,576,000.00	277,913,042.00	-337,042.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	276,576,000.00	276,576,000.00	0.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	276,576,000.00	276,576,000.00	0.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,337,042.00	-337,042.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,337,042.00	-337,042.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	00.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00	0.00
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	18.00	0.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	0.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	0.00